

“УСАН ДООРХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ” ЮНЕСКО-ИЙН 2001 ОНЫ КОНВЕНЦЫН ОРЧУУЛГА

(2001 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр, Парис хот)

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий бага хурал Парис хотноо 2001 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 3-ны өдрүүдэд болсон гучин нэгдүгээр чуулганаараа,

Усан доорх соёлын өв нь хүн төрөлхтний соёлын өвийн салшгүй хэсэг бөгөөд ард түмэн, улс үндэстний түүх болон тэдгээрийн нийтлэг өвийн талаарх хоорондын харилцааны чухал элемент болохыг хүлээн зөвшөөрч,

Усан доорх соёлын өвийг хамгаалж, хадгалахын ач холбогдол болон үүрэг хариуцлагыг оролцогч улсууд ухамсарлаж,

Усан доорх соёлын өвийн талаарх олон нийтийн сонирхол, ойлголт өсөн нэмэгдэж буйг тэмдэглэж,

Усан доорх соёлын өвийг хамгаалж, хадгалахад судалгаа, мэдээлэл болон боловсрол чухал ач холбогдолтой гэдэгт итгэж,

Усан доорх соёлын өвд хариуцлагатай, сөрөг нөлөөгүй байдлаар хандан, боловсролын болон чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжийг олон нийт эдлэх эрхтэй хэмээн үзэж, мөн уг өвийн талаарх ойлголт, үнэлэмж, хамгаалалтыг нэмэгдүүлэхэд олон нийтийн боловсрол үнэ цэнтэй гэдэгт итгэж,

Усан доорх соёлын өв, түүнд чиглэсэн зөвшөөрөлгүй үйл ажиллагаанаас болж аюулд өртөж буй нөхцөл болон ийм үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэхийн тулд илүү хүчтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг ойлгож,

Усан доорх соёлын өв санаандгүй байдлаар нөлөөлж болзошгүй хууль ёсны үйл ажиллагааны сөрөг үр дагаварт зохих ёсоор хариу арга хэмжээ авах шаардлагатай байгааг ухамсарлаж,

Усан доорх соёлын өвийг арилжааны зориулалтаар ашиглах тохиолдол, ялангуяа усан доорх соёлын өвийг худалдах, өмчилж авах эсхүл солилцоо хийх зорилготой зарим үйл ажиллагаа нэмэгдэж байгаад гүнээ зовниж,

Усан доорх соёлын өвийг илрүүлэх, түүнд хүрэх боломжийг нэмэгдүүлэх дэвшилтэт технологи байгаа болохыг анхаарч,

Усан доорх соёлын өвийг хамгаалахад улс орон, олон улсын байгууллага, шинжлэх ухааны хүрээлэн, мэргэжлийн байгууллага, археологичид, шумбагчид, сонирхсон бусад талууд болон олон нийт хоорондын хамтын ажиллагаа зайлшгүй Монгол Улсын Гадаад харилцааны нам АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН байх шаардлагатай гэдэгт итгэж,

Усан доорх соёлын өвийг судлах, малтах, хамгаалахад шинжлэх ухааны тусгай арга зүйтэй байх ба зохих техник хэрэгсэл болон тоног төхөөрөмжийг хэрэглээ;

2001 оны 11 сарын 2 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

түүнчлэн мэргэжлийн өндөр ур чадвар шаардлагатай бөгөөд эдгээрийг зохицуулах нэгдсэн шалгууртай байх хэрэгцээ үүсэж байгааг харгалзан үзэж,

ЮНЕСКО-ийн Соёлын эд зүйлийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай 1970 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Конвенц, Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай 1972 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн Конвенц, Далайн эрх зүйн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1982 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Конвенц зэрэг олон улсын хууль тогтоомж, практикт нийцүүлэн усан доорх соёлын өвийг хамгаалж, хадгалахтай холбоотой хуулийг баталж, үе шаттайгаар хөгжүүлэх шаардлагатай байгааг ухамсарлаж,

Усан доорх соёлын өвийг тухайн орчинд нь хадгалах, эсхүл шаардлагатай тохиолдолд шинжлэх ухааны болон хамгаалалтын зорилгоор хянамгай малтаж гаргахад авч хэрэгжүүлэх арга хэмжээний үр нөлөөг олон улс, бүс нутаг болон үндэсний түвшинд нэмэгдүүлэх үүргийг хүлээж,

Уг асуудлыг олон улсын Конвенцоор зохицуулах нь зүйтэй хэмээн 29 дүгээр чуулганаараа шийдвэрлэж,

2001 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр энэхүү Конвенцыг батлав.

1 дүгээр зүйл. Нэр томьёо

Конвенцын зорилго:

1. (a) “Усан доорх соёлын өв” гэж доод тал нь 100 жилийн туршид хэсэгчлэн эсхүл бүхэлдээ, тодорхой хугацааны туршид эсхүл байнга усан доор байсан соёл, түүх эсхүл археологийн шинж чанартай, хүний оролцоотой бүхий л ул мөрийг:

(i) Археологи болон байгалийн орчинтой хамт байгаа дурсгалт газар, байгууламж, барилга, олдвор болон хүний биеийн үлдэгдлийг;

(ii) Археологи болон байгалийн орчинтой байгаа хөлөг онгоц, агаарын хөлөг, бусад төрлийн тээврийн хэрэгсэл эсхүл тэдгээрийн аливаа хэсэг, ачаа эсхүл бусад эд зүйлс; болон

(iii) эртний түүхэнд хамаарах эд зүйлсийг ойлгоно.

(b) Далайн ёроолд байрлуулсан дамжуулах хоолой болон кабелийн утсыг усан доорх соёлын өв гэж үзэхгүй

(c) Дамжуулах хоолой, кабелаас бусад далайн ёроолд байрлуулсан, ашиглагдаж байгаа төхөөрөмжийг усан доорх соёлын өв гэж үзэхгүй.

2. (a) “Оролцогч Улсууд” гэдэг нь энэ Конвенцыг дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрсөн болон энэ Конвенц хүчин төгөлдөр мөрдөгдөж буй улсыг хэлнэ.

(b) Энэ Конвенцын 26 дугаар зүйлийн 2 (b) хэсэгт заасан Конвенцын нөхцөлийн дагуу талууд болсон нутаг дэвсгэрийг “Оролцогч Улс” гэж өйлгөн шаардлагад нийцүүлсэн өөрчлөлтүүдийг хийнэ.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН
Гарын үсэг /Signature/
20...оны 09 сарын 11 өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

3. “ЮНЕСКО” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагыг хэлнэ.

4. “Ерөнхий захирал” гэдэг нь ЮНЕСКО-ийн Ерөнхий захирлыг хэлнэ.

5. “Харьяалалгүй орон зай” гэж улсын нутаг дэвсгэрийн харьяаллын гадна орших далайн ёроол, далай тэнгисийн ёроол дахь газрын хэвлийг хэлнэ.

6. “Усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагаа” гэж усан доорх соёлын өвийг үндсэн объект болгон ашигладаг бөгөөд тэдгээрийг шууд болон шууд бус байдлаар бодитойгоор сүйтгэх, эсхүл гэмтээж болзошгүй үйл ажиллагааг хэлнэ.

7. “Усан доорх соёлын өвд санамсаргүй нөлөөлж буй үйл ажиллагаа” гэж усан доорх соёлын өвийг үндсэн объект эсхүл тэдний аль нэг объект болохыг үл харгалзан, усан доорх соёлын өвийг бодитойгоор сүйтгэх, гэмтээж болзошгүй үйл ажиллагааг хэлнэ.

8. “Улсын өмчийн хөлөг онгоц, агаарын хөлөг” гэдэг нь аль нэг улсын өмчлөлд эсхүл ашиглалтад байсан, живэх үедээ арилжааны бус төрийн зориулалтаар ашиглагдаж байсан нь тогтоогдсон, түүнчлэн усан доорх соёлын өвийн тодорхойлолтод хамаарах цэргийн болон бусад төрлийн хөлөг онгоц, эсхүл агаарын хөлгийг ойлгоно.

9. “Дүрэм” гэж энэхүү Конвенцын 33 дугаар зүйлд заасан, усан доорх соёлын өвд чиглэгдсэн үйл ажиллагааны дүрмийг хэлнэ.

2 дугаар зүйл. Зорилго, ерөнхий зарчим

1. Энэхүү Конвенц нь усан доорх соёлын өвийн хамгаалалтыг хангах, бэхжүүлэх зорилготой.

2. Оролцогч Улсууд усан доорх соёлын өвийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллана.

3. Оролцогч Улсууд энэхүү Конвенцын заалтад нийцүүлэн усан доорх соёлын өвийг хүн төрөлхтний ашиг тусын тулд хадгална.

4. Оролцогч Улсууд нь энэхүү Конвенц болон олон улсын хууль тогтоомжид нийцүүлэн усан доорх соёлын өвийг хамгаалахад шаардлагатай бүхий л арга хэмжээг бие даан эсхүл зохих түвшинд хамтран хэрэгжүүлэх зорилгоор өөрсдийн боломж, чадварт нийцүүлэн хамгийн боломжит арга хэрэгслийг ашиглана.

5. Усан доорх соёлын өвд чиглэсэн аливаа үйл ажиллагааг зөвшөөрөх эсхүл явуулахаас өмнө усан доорх соёлын өвийг оршин байгаа газарт нь өнөөгийн байгаа байдлаар нь хадгалах нь хамгаалалтын эхний сонголт гэж үзэх ёстой.

6. Усан доороос гарган авсан соёлын өвийг урт хугацаанд хадгалахын тулд түүнийг зохих байдлаар байрлуулж, хамгаалж, хариуцах ёстой.

7. Усан доорх соёлын өвийг арилжааны зорилгоор ашиглахыг хориглоно.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
ДЫВАТЭСНЫ ОРЧУУЛГА МӨН
Гарын үсэг /Signature/
2025 оны 05 сарын 11 өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

8. Тухайн улсын хууль тогтоомж болон олон улсын эрх зүйн хэм хэмжээ, үүний дотор Далайн эрх зүйн тухай НҮБ-ын Конвенцын дагуу энэхүү Конвенцын аль нэг ч зүйл, заалтыг олон улсын эрх зүйн дүрэм болон тусгаар улсын халдашгүй дархан эрхэд хамаарах практик, мөн аль нэг улсын өмчийн хөлөг онгоц, агаарын хөлөгтэй холбоотой тухайн улсын эдлэх эрхийг хөндөж байна гэж тайлбарлахгүй.

9. Оролцогч Улсууд далай, тэнгисийн усанд байрлах хүний үлдэгдэл хэсэгт зохих ёсоор хүндэтгэлтэй хандах нөхцөлийг хангана.

10. Усан доорх соёлын өвийн хамгаалалт болон менежментэд нийцэхгүй тохиолдлоос бусад тохиолдолд дурсгалын хамгаалалт, олон нийтийн ойлголт, үнэлэмж, өвийн хамгаалалтыг нэмэгдүүлэх зорилгоор усан доорх соёлын өвийн дурсгалт газарт нөлөөлөл үзүүлэхгүйгээр тухайн байгаа байран дээр нь ажиглах эсхүл баримтжуулахыг дэмжиж болно.

11. Энэхүү Конвенцын үндсэн дээр хэрэгжүүлэх аливаа үйлдэл, үйл ажиллагаа нь үндэсний бүрэн эрхт байдал, харьяаллын асуудлаар нэхэмжлэл гаргах, маргах үндэслэл болохгүй.

3 дугаар зүйл. Энэхүү конвенц болон далайн эрх зүйн тухай нэгдсэн үндэстний байгууллагын конвенц хоорондын хамаарал

Энэхүү Конвенцын заалтууд нь олон улсын эрх зүйн хэм хэмжээ, үүний дотор Далайн эрх зүйн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын дагуу улс орнуудын эдлэх эрх, харьяалал, үүргийг хөндөхгүй. Энэхүү Конвенцыг олон улсын эрх зүйн хэм хэмжээ, үүний дотор Далайн эрх зүйн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын хүрээнд болон түүнд нийцүүлэн тайлбарлаж, хэрэглэнэ.

4 дүгээр зүйл. Аврах ажиллагааны тухай хууль болон олдворын тухай хууль хоорондын хамаарал

Энэхүү Конвенцод хамаарах усан доорх соёлын өвтэй холбоотой аливаа ажиллагаанд аврах ажиллагаа эсхүл олдвор олох дүрмээр зохицуулахгүй ба дараах тохиолдол үүнд хамаарахгүй. Хэрэв:

- (a) эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан, болон
- (b) Энэхүү Конвенцтой бүрэн нийцэж буй, болон
- (c) тухайн ажиллагаа нь усан доорх соёлын өвийг уснаас гаргах тохиолдолд түүнийг хамгийн өндөр түвшинд хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх бол.

5 дугаар зүйл – Усан доорх соёлын өвд санамсаргүй тохиолдлоор нөлөөлж болох үйл ажиллагаа

Оролцогч Улс бүр харьяалах нутаг дэвсгэр дэх үйл ажиллагаанаас үүдэн усан доорх соёлын өвд санамсаргүй байдлаар нөлөөлж болох аливаа сөрөг үр дагавраас сэргийлэх эсхүл бууруулах хамгийн сайн боломжит арга хэрэгслийг ашиглана.



6 дугаар зүйл. Хоёр талт, бүс нутгийн эсхүл

бусад олон талт хэлэлцээрүүд

1. Оролцогч Улсууд нь усан доорх соёлын өвийг хадгалах зорилгоор хоёр талт, бүс нутгийн болон бусад олон талт хэлэлцээр байгуулах, эсхүл одоо байгаа гэрээг сайжруулж ажиллахад дэмжлэг үзүүлнэ. Ийм бүх хэлэлцээр нь энэхүү Конвенцын зүйл заалттай бүрэн нийцэж байх ёстой бөгөөд түүний нийтлэг шинж чанарыг алдагдуулахгүй байна. Улс орнууд ийм хэлэлцээр хийснээр усан доорх соёлын өвийг энэхүү Конвенцод тусгаснаас илүү сайн хамгаалж чадахуйц дүрэм, журам баталж болно.

2. Хоёр талт, бүс нутгийн болон бусад олон талт хэлэлцээрт оролцогч талууд нотлогдохуйц хамаарал бүхий, ялангуяа соёл, түүх эсхүл археологийн холбоо хамааралтай улс орнуудыг усан доорх соёлын өвийн талаарх хэлэлцээрт нэгдэхийг урьж болно.

3. Энэхүү Конвенц нь түүнийг батлагдахаас өмнө Оролцогч Улсуудын живсэн хөлөг онгоцыг хамгаалах талаар байгуулсан хоёр талт, бүс нутгийн болон олон талт бусад хэлэлцээрээр хүлээсэн, ялангуяа энэхүү Конвенцын зорилготой нийцэж байгаа эрх, үүргийг өөрчлөхгүй.

7 дугаар зүйл. Дотоодын ус, олтиргийн ус болон харьяалах тэнгис дэх усан доорх соёлын өв

1. Оролцогч Улсууд бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дотоодын ус, олтиргийн ус болон харьяалах тэнгис дэх усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагааг зохицуулах, зөвшөөрөх онцгой эрхтэй.

2. Усан доорх соёлын өвийг хамгаалахтай холбоотой бусад олон улсын хэлэлцээр, олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчихгүйгээр Оролцогч Улсууд дотоодын ус, олтиргийн ус, харьяалах тэнгис дэх усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагаанд энэхүү Дүрмийг хэрэглэнэ.

3. Олтиргийн ус болон харьяалах тэнгистээ бүрэн эрхээ хэрэгжүүлж, улс орнууд болон Оролцогч Улсын нийтлэг туршлагыг танин мэдэж, улсын өмчийн хөлөг онгоц болон нисэх онгоцыг хамгаалах хамгийн сайн арга зүйгээр хамтран ажиллахын тулд энэхүү Конвенцод нэгдсэн Оролцогч Улсын далбаа, хэрэгцээтэй тохиолдолд танигдахуйц улсын өмчийн хөлөг онгоц, агаарын хөлгийг илрүүлсэнтэй холбогдуулан бусад улсуудтай хамаарах нотлогдохуйц холбоо хамаарал, ялангуяа соёл, түүхийн эсхүл археологийн холбоо хамаарлыг тус тус мэдэгдэнэ.

8 дугаар зүйл. Залгаа бүс дэх усан доорх соёлын өв

Оролцогч Улсууд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Далайн эрх зүйн тухай Конвенцын 9, 10 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр 303 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу залгаа бүсдээ усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагааг зохицуулж, зөвшөөрөл өгч болно. Энэ тохиолдолд Дүрмийг хэрэгжүүлэхийг шаардана.



**9 дүгээр зүйл. Эдийн засгийн онцгой бүс болон эх газрын хормой дахь
мэдээлэл өгөх, мэдэгдэх**

1. Оролцогч бүх улс энэхүү Конвенцод нийцүүлэн эдийн засгийн онцгой бүс, эх газрын хормой дахь усан доорх соёлын өвийг дараах байдлаар хамгаалах үүрэгтэй. Үүний тулд:

а) Оролцогч Улсын үндэсний болон далбаа бүхий хөлөг онгоц эдийн засгийн онцгой бүс эсхүл эх газрын хормой дахь усан доорх соёлын өвийг олж илрүүлэх эсхүл түүнд чиглэсэн үйл ажиллагаа явуулах тохиолдолд харьяат иргэн болон далбаа бүхий хөлөг онгоцны ахмадыг уг нээлт эсхүл үйл ажиллагааны талаар мэдэгдэхийг Оролцогч Улс шаардана.

(b) Өөр Оролцогч Улсын эдийн засгийн онцгой бүс эсхүл эх газрын хормойд буй:

(i) Оролцогч Улсууд харьяат иргэн болон далбаа бүхий хөлөг онгоцны ахмадыг тухайн нээлт болон үйл ажиллагааны талаар тэдэнд болон бусад Оролцогч Улсад мэдэгдэхийг шаардана.

(ii) Өөрөөр, Оролцогч Улс үндэсний болон далбаа бүхий хөлөг онгоцны ахмадыг тухайн нээлт болон үйл ажиллагааны талаар мэдэгдэхийг шаардах бөгөөд тухайн мэдэгдлийг шуурхай, үр дүнтэй бусад Оролцогч Улсуудад дамжуулахад баталгаа гаргана.

2. Оролцогч Улс энэхүү Конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсхүл түүнд нэгдэн орох тухай баримт бичгээ хадгалуулахдаа энэ зүйлийн 1 (b) хэсэгт заасны дагуу тайланг хэрхэн дамжуулах талаар мэдэгдэнэ.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нээлт болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг Оролцогч Улс Ерөнхий захиралд мэдэгдэнэ.

4. Ерөнхий захирал энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан түүнд мэдэгдсэн аливаа мэдээллийг бүх Оролцогч Улсад нэн даруй нээлттэй болгоно.

5. Аль ч Оролцогч Улс эдийн засгийн онцгой бүс болон эх газрын хормой дахь усан доорх соёлын өв оршиж буй Оролцогч Улс хандаж, тухайн усан доорх соёлын өвийг хэрхэн үр дүнтэй хамгаалах талаар зөвлөлдөх сонирхолтойгоо мэдэгдэж болно. Ийм мэдэгдэл нь холбогдох усан доорх соёлын өвийн нотлогдохуйц холбоо хамаарал, ялангуяа соёл, түүхийн эсхүл археологийн холбоо хамаарал дээр үндэслэнэ.

**10 дугаар зүйл. Эдийн засгийн онцгой бүс болон эх газрын хормой дахь усан
доорх соёлын өвийн хамгаалалт**

1. Энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд эдийн засгийн онцгой бүс эсхүл эх газрын хормойд байрлах усан доорх соёлын өв рүү чиглэсэн ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохыг хориглоно.



2. Эдийн засгийн онцгой бүс болон эх газрын хормой дахь усан доорх соёлын өв оршиж буй Оролцогч Улс Далайн эрх зүйн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенц болон олон улсын хуулиар хангагдсан өөрийн бүрэн эрх эсхүл эрх мэдэлд хөндлөнгөөс оролцохоос урьдчилан сэргийлэхийн тулд усан доорх соёлын өвд чиглэсэн аливаа үйл ажиллагааг хориглох, зөвшөөрөх эрхтэй.

3. Эдийн засгийн онцгой бүс болон эх газрын хормой дахь усан доорх соёлын өв оршиж буй Оролцогч Улс усан доорх соёлын өв илэрсэн эсхүл усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагаа явуулахаар зорьж буй тохиолдолд: Оролцогч Улс:

(a) 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу сонирхлоо зарласан бусад Оролцогч Улсуудтай усан доорх соёлын өвийг хэрхэн хамгийн сайнаар хамгаалах талаар зөвлөлдөх;

(b) “Зохицуулагч улс”-ын хувиар ийм зөвлөгөөнийг зохион байгуулах ба хэрэв ийм үүрэг гүйцэтгэхгүй гэдгээ илэрхийлсэн бол 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу сонирхлоо илэрхийлсэн Оролцогч Улсууд Зохицуулагч улсыг томилно.

4. Усан доорх соёлын өвийг тонож, хулгайлах зэрэг шууд аюул хохирол үүсэхээс урьдчилан сэргийлж, олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу бүх талын боломжит арга хэмжээ авч, хамгаалах талаар оролцогч нийт улсын хүлээсэн үүргийг хөндөхгүйгээр тухайн зохицуулагч улс энэхүү Конвенцод нийцүүлэн тонож, хулгайлах зэрэг хүний үйл ажиллагаатай холбоотой эсхүл өөр шалтгаанаар үүсэх шууд аюул хохирлоос урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай бол зөвлөгөөн хийхээс өмнө бүх талын арга хэмжээ авч хэрэгжүүлэх ба / эсхүл зохих зөвшөөрлийг олгоно. Ийм төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ оролцогч бусад Оролцогч Улсаас тусламж хүсэж болно.

5. Зохицуулагч улс:

(a) зөвлөлдөж байгаа бусад улстай хамтран аль нэг өөр Оролцогч Улс арга хэмжээг хэрэгжүүлэхээр тохирсноос бусад тохиолдолд зөвлөлдөж байгаа бусад улстай хамтран тохиролцсоны дагуу хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ;

(b) зөвлөлдөж байгаа бусад улстай хамтран аль нэг өөр Оролцогч Улс зөвшөөрөл олгохыг зөвшөөрснөөс бусад тохиолдолд Конвенцын дүрэмд нийцүүлэн дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэхтэй холбоотой бүх зөвшөөрлийг олгоно;

(c) усан доорх соёлын өвийн талаар шаардлагатай бүх урьдчилсан судалгааг хийж болох бөгөөд үүнд шаардагдах бүх талын зөвшөөрлийг олгож, судалгааны дүнг Ерөнхий захиралд шуурхай мэдээлнэ. Ерөнхий захирал уг мэдээллийг оролцогч бусад улсад нээлттэй болгоно.

6. Энэ зүйлд заасны дагуу зөвлөгөөн зохион байгуулах, арга хэмжээ авч хэрэгжүүлэх, урьдчилсан судалгаа хийх болон/ эсхүл зөвшөөрөл олгохдоо тухайн зохицуулагч улс өөрийн ашиг сонирхлын үүднээс бус нийт Оролцогч улсын өмнөөс үйл ажиллагаа явуулна. Ийнхүү авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь олон улсын эрх зүйн хэм хэмжээ, үүний дотор Далайн эрх зүйн тухай Нэгдсэн Үндэстний

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЕСНЭГ ОРЧУУЛГА МОН
Гарын үсэг /Signature/
20...оны 09 сарын 11 өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Байгууллагын Конвенцоор тогтоогоогүй ямар нэгэн давуу эрх эсхүл эрх хэмжээ шаардах үндэслэл болохгүй.

7. Энэ зүйлийн 2 болон 4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд аль нэг улсын хөлөг онгоц болон агаарын хөлөг рүү чиглэсэн ажиллагааг тухайн далбааны эзэн улсын зөвшөөрөл болон Зохицуулагч улсын оролцоогүйгээр авч хэрэгжүүлэхийг хориглоно.

11 дүгээр зүйл. Харьяалалгүй орон зайг тайлагнах, мэдэгдэх

1. Оролцогч Улсууд энэхүү Конвенц болон Далайн эрх зүйн байдлын тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын 149 дүгээр зүйлд заасны дагуу харьяалалгүй орон зайд орших усан доорх соёлын өвийг хамгаалах үүрэгтэй. Үүний дагуу Оролцогч Улсын үндэсний болон далбааг мандуулж буй хөлөг онгоц харьяалалгүй орон зайд орших усан доорх соёлын өвийг олж илрүүлэх эсхүл түүнд чиглэсэн үйл ажиллагаа явуулах тохиолдолд Оролцогч Улс нь харьяат иргэн болон хөлөг онгоцны ахмадаас нээлт эсхүл үйл ажиллагааны талаар мэдээлэхийг шаардана.

2. Оролцогч Улсууд тэдэнд мэдэгдсэн нээлт, үйл ажиллагааны талаар Ерөнхий захирал болон Олон улсын далайн ёроолын асуудал эрхэлсэн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.

3. Ерөнхий захирал Оролцогч Улсуудын өгсөн аливаа мэдээллийг бүх Оролцогч Улсад нэн даруй нээлттэй болгоно.


4. Аль нэг Оролцогч Улс тухайн усан доорх соёлын өвийг хэрхэн үр дүнтэй хамгаалах талаар зөвлөлдөх сонирхолтой байгаагаа Ерөнхий захиралд мэдэгдэж болно. Ийм мэдэгдлийг тухайн усан доорх соёлын өвтэй батлагдаж болох холбоо хамаарал дээр үндэслэх бөгөөд ингэхдээ соёл, түүх, археологийн үүсэл гаралд харьяалагдах улсын давуу эрхийг түлхүү анхаарч үзнэ.

12 дугаар зүйл. Харьяалалгүй орон зайд орших усан доорх соёлын өвийн хадгалалт, хамгаалалт

1. Энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд харьяалалгүй орон зайд орших усан доорх соёлын өвд чиглэсэн аливаа үйл ажиллагаанд зөвшөөрөл олгохыг хориглоно.

2. Ерөнхий захирал 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу сонирхлоо илэрхийлсэн бүх Оролцогч Улсуудыг усан доорх соёлын өвийг хэрхэн хамгийн сайн хамгаалах талаар зөвлөлдөхийг урьж, зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах Оролцогч Улс буюу “Зохицуулагч улс”-ыг томилно. Ерөнхий захирал Олон улсын далайн ёроолын асуудал эрхэлсэн байгууллагыг уг зөвлөлдөх уулзалтад оролцохыг урина.

3. Хүний үйл ажиллагаа эсхүл тонуул гэх мэт бусад шалтгаанаас үүдэлтэйгээр усан доорх соёлын өвд учирч болзошгүй шууд аюулаас урьдчилсан сэргийлэхийн



тулд Оролцогч бүх улсууд зөвлөлдөх уулзалтаас өмнө Конвенцын дагуу боломжтой бүх арга хэмжээг авч болно.

4. Зохицуулагч улс нь:

(a) зөвлөлдөж байгаа улсууд, түүний дотор Зохицуулагч улс аль нэг өөр Оролцогч Улсаар арга хэмжээ авхуулахаар тохирсноос бусад үед зөвлөлдөж байгаа бусад улстай хамтран тохиролцсоны дагуу хамгаалах арга хэмжээ авна;

(b) зөвлөлдөж байгаа улсууд түүний дотор Зохицуулагч улсаар зөвшөөрөл олгуулахаар тохирсноос бусад үед Конвенцод нийцүүлэн дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэхтэй холбоотой бүх зөвшөөрлийг олгоно.

5. Зохицуулагч улс усан доорх соёлын өвийн талаар шаардлагатай бүх урьдчилсан судалгаа хийж болох бөгөөд үүнд шаардагдах бүх талын зөвшөөрлийг олгож, судалгааны дүнг Ерөнхий захиралд шуурхай мэдээлнэ. Ерөнхий захирал уг мэдээллийг оролцогч бусад улсад нээлттэй болгоно.

6. Энэ зүйлд заасны дагуу зөвлөгөөн зохион байгуулах, арга хэмжээ авч хэрэгжүүлэх, урьдчилсан судалгаа хийх болон/ эсхүл зөвшөөрөл олгохдоо тухайн Зохицуулагч улс өөрийн ашиг сонирхлын үүднээс бус, бүх Оролцогч Улсын өмнөөс үйл ажиллагаа явуулна. Ингэхдээ тухайн усан доорх соёлын өвтэй холбоотой соёл, түүх, археологийн үүсэл гаралд харьяалагдах улсын давуу эрхийг түлхүү анхаарч үзнэ.

7. Аль ч Оролцогч Улс харьяалалгүй орон зайд орших өөр улсын өмчийн хөлөг онгоц болон агаарын хөлөг рүү чиглэсэн ажиллагааг тухайн далбааны эзэн улсын зөвшөөрөлгүйгээр авч хэрэгжүүлэхийг хориглоно.

13 дугаар зүйл. Халдашгүй дархан эрх

Арилжааны бус зорилгоор өөрийн хэвийн горимоор ажиллаж, усан доорх соёлын өв рүү чиглэсэн ажиллагаанд оролцоогүй, халдашгүй дархан эрхтэй байлдааны хөлөг онгоц, төрийн өмчийн бусад хөлөг онгоц, байлдааны нисэх онгоц нь энэхүү Конвенцын 9, 10, 11, 12 дугаар зүйлийн дагуу усан доорх соёлын өвийг илрүүлсэн тухай мэдээлэх үүрэг хүлээхгүй. Гэхдээ арилжааны бус зорилгоор үйл ажиллагаа явуулж байгаа халдашгүй дархан эрхтэй байлдааны хөлөг онгоц, төрийн өмчийн бусад хөлөг онгоц болон байлдааны нисэх онгоцныхоо ашиглалт эсхүл ашиглах нөөц боломжийг алдагдуулахгүйгээр тухайн Оролцогч Улс нь эдгээр хөлөг онгоц болон нисэх онгоц энэхүү Конвенцын 9, 10, 11, 12 дугаар зүйлийн заалтыг дагаж мөрдүүлэх талаар боломжтой арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

14 дүгээр зүйл. Хилээр нэвтрэх, худалдах болон эзэмшихтэй холбоотой

хяналт

Оролцогч Улс бүр хууль бусаар экспортолсон болон /эсхүл энэхүү Конвенцод харшлах хэлбэрээр илрүүлсэн усан доорх соёлын өвийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэх, худалдаалах, эзэмшихийг хориглох талаар арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Борчлол, Бүтэц, Хууль
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

15 дугаар зүйл. Оролцогч Улсуудын харьяалал дахь газрыг ашиглахгүй байх

Оролцогч Улсууд өөрийн газар нутаг түүнд хамаарах далайн боомт, хиймэл арал, барилга, байгууламж зэрэг тусгай харьяалал, хяналттай газруудад усан доорх соёлын өвд чиглэсэн энэхүү Конвенцод үл нийцэх аливаа үйл ажиллагааг дэмжих, ашиглахыг хориглох арга хэмжээ авна.

16 дугаар зүйл. Иргэн болон хөлөг онгоцонд хамаарах арга хэмжээ

Оролцогч Улс харьяат иргэн болон өөрийн далбаа бүхий хөлөг онгоц энэхүү Конвенцод харшлах хэлбэрээр усан доорх соёлын өвд чиглэсэн аливаа ажиллагаа явуулахгүй байх талаар боломжтой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

17 дугаар зүйл. Хориг арга хэмжээ

1. Энэхүү Конвенцын дагуу авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ зөрчигдсөн тохиолдолд Оролцогч Улс хориг арга хэмжээ авна.

2. Энэхүү Конвенцын хэрэгжилтийг үр дүнтэй болгох, аль ч газар зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, мөн зөрчил гаргасан этгээд хууль бус ажиллагаанаасаа ашиг олох боломжийг хаах үүднээс зөрчилд авах хориг арга хэмжээ хүнд, хөнгөнийг зохих түвшинд байлгахаар тогтооно.

3. Оролцогч Улсууд энэ зүйлийн дагуу авсан хориг арга хэмжээг хэрэгжүүлэхийн төлөө хамтран ажиллана.

18 дугаар зүйл. Усан доорх соёлын өвийг хураан авах, хадгалах

1. Оролцогч Улс бүр өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд энэхүү Конвенцод харшлах аливаа аргаар усан доороос гарган авсан соёлын өвийг хураан авах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2. Оролцогч Улс бүр энэхүү Конвенцын дагуу хураан авсан усан доорх соёлын өвийг бүртгэх, хамгаалах болон түүний тогтвортой байдлыг хадгалах талаар бүх талын зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3. Оролцогч Улс бүр Конвенцын дагуу усан доорх соёлын өвийг хураан авсан талаар Ерөнхий захирал болон тухайн усан доорх соёлын өвтэй соёл, түүх эсхүл археологийн холбоо хамааралтай нь нотлогдсон бусад улсад мэдэгдэнэ.

4. Усан доорх соёлын өвийг хураан авсан Оролцогч Улс тухайн өвийн хадгалалт, хамгаалалт, судалгааны хэрэгцээ, тарж салсан цуглуулгын нэгдмэл цогц байдлыг хангах хэрэгцээ, үзэсгэлэн, боловсролын зориулалтаар олон нийтийн хүртээл болгох хэрэгцээг харгалзан үзэж, тухайн өвтэй соёл, түүх эсхүл археологийн холбоо хамааралтай нь нотлогдсон улсын сонирхлыг хүндэтгэж, олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн усан доорх соёлын өвийг нийтийн ашиг тусын төлөө хадгалж, ашиглана.



19 дүгээр зүйл. Хамтын ажиллагаа болон мэдээлэл солилцох

1. Оролцогч Улс энэхүү Конвенцын дагуу усан доорх соёлын өвийн хамгаалалт, удирдлагын хүрээнд ялангуяа хайгуул, малтлага, баримтжуулалт, хадгалалт, судалгаа болон өвийг танилцуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллаж, харилцан дэмжлэг үзүүлнэ.

2. Оролцогч Улс бүр энэхүү Конвенцын зорилгод нийцэх хүрээнд усан доорх соёлын өвийг илрүүлсэн тухай, өвийн байршил, Конвенцод үл нийцэх эсхүл Олон улсын хууль тогтоомжийг зөрчиж өвийг малтсан эсхүл усан доороос гарган авсан, холбогдох шинжлэх ухааны арга зүй, технологи, болон тухайн өвтэй холбоотой хууль эрхзүйн зохицуулалтын өөрчлөлтийн талаарх мэдээллийг Оролцогч Улсуудтай хуваалцах үүргийг хүлээнэ.

3. Усан доорх соёлын өвийг илрүүлсэн эсхүл түүний байршлыг тогтоосон талаар Оролцогч Улс хооронд, эсхүл ЮНЕСКО болон Оролцогч Улс хооронд солилцсон мэдээллийг ил болгох нь усан доорх тухайн соёлын өвийг хадгалж үлдээхэд аюул заналхийлэл учруулах эсхүл өөр хэлбэрээр эрсдэл үүсгэж байгаа бол тухайн мэдээллийг холбогдох Оролцогч Улсуудын дотоодын хууль тогтоомжид нийцүүлэх хүрээнд нууцалж, зөвхөн Оролцогч Улсын эрх бүхий байгууллагуудад танилцуулна.

4. Оролцогч Улс бүр энэхүү Конвенц эсхүл олон улсын эрх зүйн бусад хэм хэмжээг зөрчин малтлага хийж эсхүл сэргээн авсан усан доорх соёлын өвийн талаарх мэдээллийг тараах, үүний дотор боломжтой бол олон улсын холбогдох мэдээллийн санг ашиглан түгээх талаар хэрэгжүүлж болох бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

20 дугаар зүйл. Олон нийтийн мэдлэг ойлголт

Оролцогч Улс бүр усан доорх соёлын өвийн үнэ цэн, ач холбогдол болон тус Конвенцын дагуу усан доорх соёлын өвийг хамгаалах ач холбогдлын талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх боломжит арга хэмжээг авна.

21 дүгээр зүйл. Усан доорх археологийн сургалт

Оролцогч Улсууд усан доорх археологийн сургалтыг хүртээмжтэй байлгах, усан доорх соёлын өвийг хадгалж, хамгаалах арга техник болон тохиролцсон нөхцөлд усан доорх соёлын өвтэй холбоотой технологийг дамжуулах чиглэлээр хамтран ажиллана.

22 дугаар зүйл. Эрх бүхий байгууллага

1. Энэхүү Конвенцыг зохих түвшинд хэрэгжүүлэх үүднээс Оролцогч Улсууд усан доорх соёлын өвийн бүртгэл бий болгох, түүнийг хөтлөх болон шинэчлэх, усан доорх соёлын өвийг үр дүнтэйгээр хамгаалах, хадгалж үлдээх, нийтэд танилцуулах, харж хандах, мөн эрдэм шинжилгээний болон боловсролын зорилгоор эрх бүхий

Гарын үсэг /Signature/

20...оны...сарын...өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

байгууллагыг үүсгэн байгуулж, эсхүл шаардлагатай тохиолдолд одоо байгаа байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлнэ.

2. Оролцогч Улсууд усан доорх соёлын өвтэй холбоотой эрх бүхий байгууллагын нэр, хаягийг Ерөнхий захиралд мэдэгдэнэ.

23 дугаар зүйл. Оролцогч Улсуудын хурал

1. Ерөнхий захирал энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор, цаашид хоёр жил тутамд нэгээс доошгүй удаа Оролцогч Улсуудын хурлыг зарлан хуралдуулна. Оролцогч Улсуудын олонхын хүсэлтээр Ерөнхий захирал Оролцогч Улсуудын Ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

2. Оролцогч Улсуудын хурлаар хурлын чиг үүрэг, хариуцлагын талаар шийдвэр гаргана.

3. Оролцогч Улсуудын хурал өөрийн үйл ажиллагааны Дүрмийг батална.

4. Оролцогч Улсуудын хурлаар Оролцогч Улсуудаас нэр дэвшүүлсэн шинжээчдээс бүрдсэн Шинжлэх ухаан, техникийн зөвлөх багийг газарзүйн тэгш хуваарилах зарчим болон жендэрийн тэнцвэрт байдалд нийцүүлэн байгуулж болно.

5. Шинжлэх ухаан, техникийн зөвлөх баг нь Конвенцын дүрмийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гарах шинжлэх ухаан, техникийн чанартай асуудлаар Оролцогч Улсын хуралд зохих ёсны туслалцаа үзүүлнэ.

24 дүгээр зүйл. Конвенцын Нарийн бичгийн дарга нарын газар

1. Ерөнхий захирал энэхүү Конвенцын Нарийн бичгийн дарга нарын газрын чиг үүргийг хариуцна.

2. Нарийн бичгийн дарга нарын газрын чиг үүрэг нь:

(a) 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Оролцогч Улсуудын хурлыг зохион байгуулах;

(b) Оролцогч Улсуудын хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхэд Оролцогч Улсуудад дэмжлэг үзүүлэх.

25 дугаар зүйл. Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх

1. Энэхүү Конвенцыг тайлбарлах, хэрэглэхтэй холбоотойгоор хоёр буюу түүнээс дээш Оролцогч Улсын хооронд гарсан аливаа маргааныг сайн санааны үндсэн дээр хэлэлцээр хийж эсхүл өөрсдийн сонгосон эв зүйгээр зохицуулах өөр аргаар шийдвэрлэнэ.

2. Эдгээр хэлэлцээ нь маргааныг зохих хугацаанд шийдвэрлээгүй тохиолдолд Оролцогч Улсуудын зөвшилцсөнөөр эвлэрүүлэн зуучлахыг хүсэж ЮНЕСКО-д хандаж болно.



3. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа зохион байгуулагдаагүй эсхүл эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд энэ Конвенцыг тайлбарлах, хэрэглэхтэй холбоотойгоор энэ Конвенцод Оролцогч Улсуудын хооронд үүссэн аливаа маргаанд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Далайн эрхзүйн байдлын тухай Конвенцод Оролцогч эсэхээс үл хамааран Нэгдсэн Үндэстний Байгууллагын Далайн эрх зүйн байдлын тухай Конвенцын XV хэсэгт заасан маргааныг шийдвэрлэх заалтыг ашиглан шаардлагатай зохицуулалтыг хийнэ.

4. Энэхүү Конвенцын болон Далайн эрх зүйн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын Оролцогч Улс Далайн эрх зүйн тухай НҮБ-ын Конвенцын 287 дугаар зүйлийн дагуу сонгосон журмыг энэ зүйлд дурдсан маргааныг шийдвэрлэх ажиллагаанд ашиглана. Тухайн Оролцогч Улс Далайн эрх зүйн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын 287 дугаар зүйлд заасны дагуу энэхүү Конвенцтой холбоотой үүсэх маргааныг шийдвэрлэх ажиллагаанд өөр журмыг энэхүү Конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсхүл түүнд нэгдэн ороход эсхүл дараа нь сонгосон бол үүнд хамаарахгүй.

5. Далайн эрх зүйн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын оролцогч тал болоогүй энэхүү Конвенцын Оролцогч Улс нь энэхүү Конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл түүнд нэгдэн орохдоо эсхүл дараа нь Далайн эрх зүйн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын 287 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан аргуудаас аль нэгийг эсхүл хэд хэдийг энэ зүйлд заасан маргааныг шийдвэрлэх зорилгоор бичгээр мэдэгдэл гаргах замаар сонгох эрхтэй. 287 дугаар зүйл нь ийнхүү гаргасан мэдэгдлийн хувьд, түүнчлэн түүнд дурдагдаагүй боловч мэдэгдэл гаргасан тухайн Оролцогч Улс нэг тал нь болж байгаа бусад маргааны хувьд үйлчилнэ. Далайн эрх зүйн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын V болон VII хавсралтад заасан эвлэрүүлэх журам болон арбитрын шүүхийн зорилгын хүрээнд тухайн Оролцогч Улс нь энэхүү Конвенцтой холбоотой үүсэх маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэгч, арбитрын шүүгчийг V хавсралтын 2 дугаар зүйл болон VII хавсралтын 2 дугаар зүйлд дурдсан жагсаалтад оруулахаар нэрийг нь дэвшүүлэх эрхтэй.

26 дугаар зүйл. Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсхүл нэгдэн орох

1. ЮНЕСКО-ийн гишүүн улсууд энэхүү Конвенцыг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, эсхүл батална.

2. Дараах этгээд энэхүү Конвенцод нэгдэж орно. Үүнд:

(a) ЮНЕСКО-ийн гишүүн биш боловч Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллага эсхүл Олон улсын атомын энергийн агентлагийн гишүүн улс, түүнчлэн Олон улсын шүүхийн дүрмийн Оролцогч Улс болон ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлаас энэхүү Конвенцод нэгдэн орохыг урьсан бусад улс;

b) Нэгдсэн Үндэстний Байгууллагаас хүлээн зөвшөөрснөөр дотоодоо өөрийгөө удирдах бүрэн эрхтэй боловч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейн 1514 (XV) тогтоолын дагуу тусгаар тогтнолоо бүрэн аваагүй байгаа ба...



энэхүү Конвенцоор зохицуулагдах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үүний дотор эдгээр асуудлаар олон улсын гэрээ байгуулах эрх мэдэлтэй нутаг дэвсгэр зэрэг хамаарна.

3. Конвенцыг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан болон түүнд нэгдэн орсон тухай баримт бичгийг Ерөнхий захиралд хадгалуулна.

27 дугаар зүйл. Хүчин төгөлдөр болох

Энэхүү Конвенц нь 26 дугаар зүйлд дурдсан хорь дахь баримт бичгийг 20 дахь улс хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно, ингэхдээ баримт бичгээ хадгалуулсан хорин улс эсхүл нутаг дэвсгэрийн хүрээнд хүчин төгөлдөр болно. Харин бусад улсын хувьд тухайн улс баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

28 дугаар зүйл. Дотоодын усны тухай мэдэгдэл

Энэхүү Конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсхүл нэгдэн орох үед түүний дараа аль ч улс эсхүл нутаг дэвсгэр Дүрмийг далайн шинж чанартай биш дотоодын усанд мөрдөх тухай мэдэгдэж болно.

29 дүгээр зүйл. Газарзүйн хамрах хүрээний хязгаарлалт

Конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох үед тухайн улс эсхүл нутаг дэвсгэр, нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг, дотоодын ус, олтиргийн ус эсхүл харьяа тэнгист энэхүү Конвенц үйлчлэхгүй болохыг хадгалуулах баримт бичигт мэдэгдэх бөгөөд мөн энэ мэдэгдлийн шалтгааныг тодорхойлно. Мэдэгдэл гаргагч улс нь мэдэгдэлд заасан газар нутагт Конвенцын ашиглах хүрээ, нөхцөлийг аль болох хурдан, боломжтой хэмжээнд тодорхой болгох бөгөөд биелүүлсэн даруйд мэдэгдлийг бүхэлд нь эсхүл буюу хэсэгчлэн эгүүлэн татна.

30 дугаар зүйл. Тайлбар хийх

29 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд энэхүү Конвенцод тайлбар хийж үл болно.

31 дүгээр зүйл. Нэмэлт өөрчлөлт

1. Оролцогч Улс Ерөнхий захиралд бичгээр мэдэгдэл хүргүүлэн энэхүү Конвенцод нэмэлт өөрчлөлт оруулах саналаа гаргаж болно. Ерөнхий захирал ийм мэдэгдлийг оролцогч бүх улсад хүргүүлнэ. Хэрэв ийм мэдэгдлийг хүргүүлсэн өдрөөс хойш зургаан сарын дотор Оролцогч Улсын тэн хагасаас доошгүй хувь нь дэмжсэн хариу өгсөн бол Ерөнхий захирал нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хэлэлцүүлж, батлуулахаар Оролцогч Улсын ээлжит хуралд тухайн саналыг танилцуулна.

2. Нэмэлт өөрчлөлтийг санал хураалтад оролцсон нийт Оролцогч Улсын гуравны хоёрын саналаар батална.



3. Энэхүү Конвенцод оруулах нэмэлт өөрчлөлтийг баталсны дараа Оролцогч Улсууд түүнийг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, баталж эсхүл түүнд нэгдэн орно.

4. Нэмэлт өөрчлөлт нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан баримт бичгийг Оролцогч Улсын гуравны хоёр нь хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа түүнийг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, баталж эсхүл түүнд нэгдэн орсон Оролцогч Улсын хувьд хүчин төгөлдөр үйлчилнэ. Үүнээс хойш нэмэлт өөрчлөлт нь түүнийг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, баталж эсхүл түүнд нэгдэн орсон улс эсхүл нутаг дэвсгэр холбогдох баримт бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа тухайн улс эсхүл нутаг дэвсгэрийн хувьд хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа энэхүү Конвенцын оролцогч тал болсон аливаа улс эсхүл нутаг дэвсгэр өөрөөр хүсэл зорилго илэрхийлээгүй бол тухайн улс эсхүл нутаг дэвсгэрийг:

(a) Нэмэлт өөрчлөлт оруулсан Конвенцын Оролцогч тал; болон

(b) нэмэлт өөрчлөлтийг зөвшөөрөөгүй аливаа Оролцогч Улсын хувьд нэмэлт өөрчлөлт ороогүй конвенцын оролцогч тал болно гэж тус тус авч үзнэ.

32 дугаар зүйл. Цуцлах

1. Оролцогч Улс энэхүү Конвенцыг цуцалсан тухайгаа бичгээр үйлдэж Ерөнхий захиралд хадгалуулна.

2. Цуцлах өдрийг мэдэгдэлд өөрөөр заагаагүй тохиолдолд цуцалсан тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш арван хоёр сарын дараа цуцлалт хүчин төгөлдөр болно.

3. Конвенцыг цуцлах нь аливаа Оролцогч Улсад уг Конвенцод тусгагдсан олон улсын эрх зүйн хүрээнд хамаарах аливаа үүргээ биелүүлэхэд нөлөөлөхгүй.

33 дугаар зүйл. Дүрэм

Энэхүү Конвенцын хавсралтад орсон Конвенцын дүрэм нь түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох бөгөөд өөрөөр шууд заагаагүй тохиолдолд энэхүү Конвенцыг иш татсан бол конвенцын дүрмийг мөн иш татсан гэж үзнэ.

34 дүгээр зүйл. Нэгдсэн Үндэстний Байгууллагад бүртгүүлэх

Нэгдсэн үндэстний байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу энэхүү Конвенцыг ЮНЕСКО-ийн Ерөнхий захирлын хүсэлтээр Нэгдсэн үндэстний байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

35 дугаар зүйл. Эх бичвэрүүд адил хүчинтэй байх

Энэхүү Конвенцыг Араб, Хятад, Англи, Франц, Орос болон Испани хэл дээр үйлдсэн бөгөөд эдгээр зургаан эх бичвэр нь адил хүчинтэй байна.



УСАН ДООРХ СОЁЛЫН ӨВД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

I. Ерөнхий зарчим

Дүрэм 1. Усан доорх соёлын өвийг оршин буй газарт нь хадгалж, хамгаалахыг хадгалалт, хамгаалалтын эхний сонголт гэж үзнэ. Энэ дагуу усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагааг тухайн өвийг хамгаалахтай нийцүүлэн зөвшөөрөх бөгөөд усан доорх соёлын өвийг хамгаалах, эсхүл мэдлэг ойлголт, эсхүл нөхцөл байдлыг сайжруулахад үнэмлэхүй хувь нэмэр оруулах зорилго бүхий үйл ажиллагаанд зөвшөөрөл олгож болно.

Дүрэм 2. Усан доорх соёлын өвийг худалдах эсхүл ашиг хонжоо олох зорилгоор эсхүл эргэн нөхөгдөшгүйгээр тараан задруулах нь тухайн өвийг хамгаалах, зохистой удирдах зарчимтай нийцэхгүй. Усан доорх соёлын өвийг арилжааны бараа болгон худалдах, зарах, худалдаж авах, солилцохыг хориглоно.

Энэ дүрмийг дараах зүйлийг хориглох зорилгоор тайлбарлахгүй:

(a) Зорилго, чиглэл нь энэхүү Конвенцод бүрэн нийцсэн, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй археологийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх эсхүл үүнтэй холбоотой шаардлагатай үйл ажиллагаа явуулах арга хэмжээ авах;

(b) Конвенцын дагуу зохион байгуулагдсан судалгааны явцад гарган авсан усан доорх соёлын өвийн үлдцийг Дүрмийн 33 болон 34 дэх хэсэгт заасны дагуу эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр түүний шинжлэх ухаан эсхүл соёлын ач холбогдол, гарган авсан материалын бүрэн бүтэн байдал эсхүл эргэн нөхөгдөшгүй байдалд нөлөөлөхгүй байхаар хадгална.

Дүрэм 3. Усан доорх соёлын өвд чиглэсэн ажиллагаа нь төслийн зорилгод шаардагдах хэмжээнээс илүүтэйгээр тухайн усан доорх соёлын өвд сөрөг нөлөөлөл үзүүлэхийг хориглоно.

Дүрэм 4. Усан доорх соёлын өвд чиглэсэн ажиллагаанд олдворыг гарган авснаас илүү түүнд гэмтэл учруулахгүй байх техник хэрэгсэл болон судалгааны арга зүйг түлхүү ашиглана. Усан доорх соёлын өвийн талаар шинжлэх ухааны судалгаа хийх эсхүл түүнийг цаашдаа хамгаалах зорилгоор малтлага хийж гаргах эсхүл уснаас гарган авах шаардлагатай байгаа бол ашиглагдах арга зүй, техник хэрэгсэл нь тухайн олдворт аль болох гэмтэл учруулахгүй ба түүнийг хадгалж үлдээхэд хувь нэмэр үзүүлэхээр байна.

Дүрэм 5. Усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагаа нь хүний биеийн үлдэгдэл эсхүл сүсэг бишрэл бүхий дурсгалт газруудад эвдрэл учруулахаас зайлсхийнэ.

Дүрэм 6. Усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагааг соёл, түүхийн болон археологийн мэдээллийг зохих ёсоор баримтжуулах зорилгоор хатуу журамлана.



Дүрэм 7. Хамгаалалт, менежменттэй нийцэхгүйгээс бусад тохиолдолд анх байрлаж буй усан доорх соёлын өвийн дурсгалт газрыг олон нийтийн хүртээл болгохыг дэмжинэ.

Дүрэм 8. Археологичид болон бусад холбогдох мэргэжилтнүүдийн үр дүнтэй солилцоо, усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор усан доорх соёлын өвд чиглэсэн олон улсын хамтын ажиллагааг дэмжинэ.

II. Төслийн баримт бичиг

Дүрэм 9. Усан доорх соёлын өвд чиглэсэн аливаа үйл ажиллагааг явуулахаас өмнө тухайн үйл ажиллагааны төслийн баримт бичгийг боловсруулж, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч болон зохих хөндлөнгийн хяналт үнэлгээг хийлгэнэ.

Дүрэм 10. Төслийн загвар дараах бүрдэлтэй байна:

- (a) Өмнөх эсхүл урьдчилсан судалгааны үнэлгээ;
- (b) Төслийн агуулга болон зорилго;
- (c) Ашиглах арга зүй болон техник;
- (d) Санхүүжүүлэх эх үүсвэр;
- (e) Төслийн дуусгавар болгох хугацаа;
- (f) Багийн бүрэлдэхүүн, багийн гишүүн бүрийн мэргэшил, үүрэг хариуцлага болон туршлага;
- (g) Хээрийн судалгааны ажлын дараах судалгаа шинжилгээ болон бусад үйл ажиллагааны төлөвлөгөө;
- (h) Эрх бүхий байгууллагатай нягт хамтарч, эд өлгийн зүйл болон дурсгалт газрыг хадгалж, хамгаалах хөтөлбөр;
- (i) Төслийг хэрэгжүүлэх хугацаан дахь дурсгалт газрын менежмент болон арчилгааны бодлого;
- (j) Баримтжуулалтын хөтөлбөр;
- (k) Аюулгүй байдлын бодлого;
- (l) Байгаль орчны бодлого;
- (m) Музей болон бусад байгууллагууд, ялангуяа шинжлэх ухааны байгууллагатай хамтран ажиллах зохицуулалт;
- (n) Тайлан боловсруулах;
- (o) Архив, үүний дотор уснаас гарган авсан соёлын өвийг хадгалуулахаар хүлээлгэн өгөх ажиллагаа; болон
- (p) Хэвлэн нийтлэх хөтөлбөр зэрэг орно.

Дүрэм 11. Эрх бүхий байгууллагаас баталсан төслийн баримт бичгийн дагуу усан доорх соёлын өвд чиглэсэн ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

Дүрэм 12. Гэнэтийн нээлт хийх эсхүл нөхцөл байдал өөрчлөгдөх тохиолдолд эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр төслийн баримт бичгийг дахин нягталж, нэмэлт өөрчлөлт оруулна.

Дүрэм 13. Усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагаа, яаралтай эсхүл санамсаргүй байдлаар илэрсэн нээлтийн үед түүнийг богино хугацаанд хадгалах...



арга хэмжээ авах, эсхүл үйл ажиллагаа явуулах, ялангуяа дурсгалт газрыг тогтворжуулах, усан доорх соёлын өвийг хамгаалах зорилгоор төслийн баримт бичигт байхгүй үйл ажиллагаанд зөвшөөрөл өгч болно.

III. Бэлтгэл ажил

Дүрэм 14. Дүрэм 10 (а) -д дурдсан урьдчилсан ажлын үнэлгээнд усан доорх соёлын өвийн ач холбогдол болон эмзэг байдал, төсөл хэрэгжсэнээр байгаль орчинд үзүүлэх эвдрэл гэмтэл, төслийн зорилгод нийцсэн мэдээлэл олж авах боломж зэргийг багтаана.

Дүрэм 15. Мөн үнэлгээнд түүх, археологийн баримтад холбогдох судалгаа, дурсгалт газрын археологи болон хүрээлэн буй орчны шинж чанар, аливаа үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн усан доорх соёлын өвийн урт хугацааны тогтвортой байдалд учирч болзошгүй үр дагаврыг оруулна.

IV. Төслийн зорилго, арга зүй болон техник

Дүрэм 16. Арга зүй нь төслийн зорилгод нийцсэн байх ёстой бөгөөд ашигласан техник нь аль болох нөлөөлөл үзүүлэхгүй байх ёстой.

V. Санхүүжилт

Дүрэм 17. Усан доорх соёлын өвийг хамгаалах яаралтай тохиолдлоос бусад тохиолдолд гарган авсан аливаа олдворыг хадгалж, хамгаалах, баримтжуулах, сан хөмрөгт авах, тайлан боловсруулах болон түгээн дэлгэрүүлэх зэрэг төслийн бүх үе шатыг дуусгахад хангалттай санхүүгийн үүсвэрийг аливаа үйл ажиллагааны өмнө баталгаажуулсан байна.

Дүрэм 18. Төслийн баримт бичиг нь төсөл хэрэгжиж дуусах хүртэл түүнийг санхүүжүүлэх, тухайлбал, бонд гаргах боломжийг нотлон харуулсан байна.

Дүрэм 19. Төслийн загварт хүлээгдэж буй санхүүжилт тасалдсан тохиолдолд дэмжих баримт бичиг болон усан доорх соёлын өвийг хадгалж, хамгаалах болзошгүй арга хэмжээний төлөвлөгөө багтсан байна.

VI. Төслийн үргэлжлэх хугацаа – Цагийн хуваарь

Дүрэм 20. Усан доороос гарган авсан олдворыг хадгалах, баримтжуулах, эмхлэх, тайлан бэлтгэх, түгээн дэлгэрүүлэх зэрэг төслийн баримт бичигт тусгагдсан усан доорх соёлын өвд чиглэсэн бүхий л үе шатыг дуусгавар болгохыг баталгаажуулж, цаг хугацааг хангалттай төлөвлөх ёстой.

Дүрэм 21. Төслийн баримт бичиг нь төслийг зогсоох эсхүл цуцлах үед усан доорх соёлын өв болон түүнтэй холбоотой баримт бичгийг хадгалж үлдээх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний нөөц төлөвлөгөөг багтаасан байна.



VII. Ур чадвар, мэргэшил

Дүрэм 22. Усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагааг зөвхөн төсөлд тохирсон шинжлэх ухааны ур чадвартай, усан доорх археологиор мэргэшсэн хүний байнгын удирдлага, хяналт дор зохион байгуулна.

Дүрэм 23. Төслийн багийн бүх гишүүд төсөлд гүйцэтгэх үүрэгтээ тохирсон мэргэжлийн ур чадвартай байх бөгөөд түүнийгээ нотлон харуулсан байна.

VIII. Хадгалалт болон дурсгалт газрын менежмент

Дүрэм 24. Хадгалалтын хөтөлбөр нь усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагааны үеэр болон тээвэрлэлтийн явцад, мөн урт хугацааны туршид археологийн олдворын хадгалалт, хамгаалалтын арга зүйг хангана. Хадгалалт, хамгаалалтыг хүчин төгөлдөр үйлчилж байгаа мэргэжлийн стандартын дагуу гүйцэтгэнэ.

Дүрэм 25. Дурсгалт газрын менежментийн хөтөлбөр нь судалгааны ажил хийх явцад болон дууссаны дараа анх олдсон газраа буй усан доорх соёлын өвийг хамгаалах, удирдах ажлыг хангах ёстой. Хөтөлбөрт олон нийтэд зориулсан мэдээлэл, дурсгалт газрыг тогтворжуулах, хяналт тавих болон хөндлөнгийн оролцооноос хамгаалах талаар зохих заалтыг тусгасан байна.

IX. Баримтжуулалт

Дүрэм 26. Баримтжуулалтын хөтөлбөр нь археологийн баримтжуулалтын одоо үйлчилж байгаа мэргэжлийн стандартын дагуу усан доорх соёлын өвд чиглэсэн үйл ажиллагааны явцын тайлан зэрэг баримтжуулалтыг бүрдүүлнэ.

Дүрэм 27. Баримтжуулахдаа усан доорх соёлын өв рүү чиглэсэн ажиллагааны явцад нүүлгэн шилжүүлсэн эсхүл уснаас гарган авсан усан доорх соёлын өвийн гарал үүслийн талаарх мэдээлэл, хээрийн тэмдэглэл, төлөвлөгөө, схем зураг, зүсэлтийн зураг болон бусад эх үүсвэрт агуулагдах гэрэл зураг эсхүл бичлэг зэрэг эргэн тойрны газрын талаарх иж бүрэн баримтыг заавал бүрдүүлсэн байна.

X. Аюулгүйн ажиллагаа

Дүрэм 28. Аюулгүйн ажиллагааны дүрмийг төслийн баг болон гуравдагч этгээдийн аюулгүй байдал болон эрүүл мэндийг зохих ёсоор хамгаалсан, мөн хүчин төгөлдөр байгаа хууль тогтоомж болон мэргэжлийн байгууллагын шаардлагад нийцсэн байхаар боловсруулна.

XI. Байгаль орчин

Дүрэм 29. Далайн ёроол, далайн амьдралыг зүй бусаар хөндөхгүй байхад чиглэсэн байгаль орчны зохих бодлогыг боловсруулна.



XII. Тайлагнах

Дүрэм 30. Төслийн ажлын хуваарьт заасны дагуу завсрын болон эцсийн тайланг боловсруулж, холбогдох нийтийн архивын албанд хадгалуулна.

Дүрэм 31. Тайланд дараах мэдээллийг багтаана. Үүнд:

- (a) Зорилгын тайлан;
- (b) Ашигласан арга зүй, техникийн тайлан;
- (c) Хүрсэн үр дүнгийн тайлан;
- (d) Үйл ажиллагааны бүх үе шатыг харуулсан анхан шатны бүдүүвч болон гэрэл зургийн баримтжуулалт;
- (e) Дурсгалт газрын болон нүүлгэн шилжүүлсэн усан доорх соёлын өвийн хадгалалт, бүртгэлийн талаарх зөвлөмж; болон
- (f) Ирээдүйн үйл ажиллагааны зөвлөмж.

XIII. Төслийн архивыг хадгалах

Дүрэм 32. Төслийн архивын хадгалалт, зохион байгуулалтыг аливаа үйл ажиллагаа эхлэхээс өмнө зөвшилцөж, төслийн төлөвлөгөөнд тусгасан байна.

Дүрэм 33. Уснаас гарган авсан аливаа усан доорх соёлын өв орсон төслийн архив болон түүнтэй холбоотой бүх баримт бичгийн хуулбарыг цуглуулаг хэлбэрээр аль болох хамт цуг, иж бүрэн байхаар, мөн мэргэжилтнүүд болон олон нийт танилцах боломжтой байхаар архивын бүрэн байдлыг хангаж хадгална. Энэ ажлыг усан доорх соёлын өвийг хадгалж үлдээх зорилгод зохих ёсоор нийцүүлэн ямар ч тохиолдолд төсөл хэрэгжүүлж дууссанаас хойш 10 жилийн дотор аль болох хурдан хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Дүрэм 34. Төслийн архивыг олон улсын мэргэжлийн стандартын дагуу удирдан зохицуулах бөгөөд зөвшөөрлийг эрх бүхий байгууллага олгоно.

XIV. Түгээн дэлгэрүүлэлт

Дүрэм 35. Төсөл нь олон нийтийн боловсролыг нэмэгдүүлэх, төслийн үр дүнг нийтийн хүртээл болгох зорилгыг агуулсан байна.

Дүрэм 36. Төслийн эцсийн бүрдлийг:

(a) төслийн нарийвчлал, нууцлал эсхүл мэдээлэл эмзэг байх шинжийг харгалзан үзсэний үндсэн дээр аль болох богино хугацааны дотор хэвлэн нийтэлж; мөн

(b) холбогдох олон нийтийн архивын газарт хадгалуулахаар өгнө.

Дээрх нь Парис хотноо хуралдаж, 2001 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр өндөрлөсөн Нэгдсэн Үндэстний Боловсрол, соёл шинжлэх ухаан болон соёлын байгууллагын Ерөнхий бага хурлын 31 дүгээр чуулганаар батлагдсан Конвенцын жинхэнэ эх бичвэр болно.

Дээрхийг гэрчилж 2001 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр гарын үсэг зурав.

